

ДОРНОГОВЬ АЙМАГ, УЛААНБАДРАХ СУМ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын
нэр:

**Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга
барих**

Тендер
шалгаруулалтын
дугаар:

ДГАХААГ/20240101030

2024 он

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	7
1. Тендерийн цар хүрээ	7
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг	7
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж	7
4. Худалдан авах ажиллагааны цахим систем	7
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх	7
6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага	7
7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага	8
Б.АГУУЛГА	8
8. Тендер шалгаруулалтын баримт бичиг	8
9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	9
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	9
11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах	9
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	9
12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл	9
13. Тендерийн иж бүрдэл.....	10
14. Тендерийн жишиг маягтууд	10
15. Хувилбарт санал	10
16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг	11
17. Чадавхын болон туршлагын шаардлага	11
18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт	11
19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ..	12
20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	12
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт	12
22. Тендерийн валют.....	13
23. Тендер хүчинтэй байх хугацаа	13
24. Тендерийн баталгаа	13
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ.....	14
25. Тендер баталгаажуулах, илгээх	14
26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	14
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	14

27.	Тендерийн талаар тодруулга авах	14
28.	Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	14
29.	Тендерийг үнэлэх	15
30.	Арифметик алдааг залруулах.....	15
31.	Давуу эрх олгох	15
32.	Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	15
33.	Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	15
34.	Тендерийг эрэмбэлэх	15
35.	Оролцогчийн чадавхыг дахин магадлах	15
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ		16
36.	Мэдэгдэл хүргүүлэх	16
37.	Гүйцэтгэлийн баталгаа.....	16
38.	Урьдчилгаа төлбөр.....	16
39.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	16

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

A.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2.Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1.Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1.Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1.Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1.Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1.Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2.Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б. АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3.Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер

бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2. Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14. Тендерийн жишиг маягтууд

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15. Хувилбарт санал

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг

тендерийн хамт ирүүлж болно.

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

16.1.Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2.Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3.Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4.Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17. Чадавхын болон туршлагын шаардлага

17.1.Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2.Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3.Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4.Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5.Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох

18.1.Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага

баримт

хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх

бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3.Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4.ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5.ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6.Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2.Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1.Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах

ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2.Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3.Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1.Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2.ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт **Error! Reference source not found.**7-ын дагуу н ууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2.Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1.Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1.Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар

авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 29.2. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.3. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног

төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадална.

35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 36. Шийдвэр хүргүүлэх** 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 37. Гүйцэтгэлийн баталгаа** 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Урьдчилгаа төлбөр** 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.
- 38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах** 39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Дорноговь аймаг, Улаанбадрах сум, Засаг даргын Тамгын газар
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга барих
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: ДГАХААГ/20240101030
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “Багцгүй”
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Аймгийн орон нутгийн төсөв
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 480,000,000 төгрөг
Б. АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Газрын даамал Ц.Оюунцэцэг Хаяг: Дорноговь аймаг, Улаанбадрах сум, 4-р баг Утасны дугаар: 99345660, 95933995 Цахим шуудангийн хаяг: zdtg@ulaanbadrah.do.gov.mn
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: “Монгол хэл”
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 16.1.2	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана” - Татварын байгууллагын тодорхойлолт: “Өргүй” - Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт: “Өргүй” - Шүүхийн байгууллагын тодорхойлолт: “Өргүй” - Эрхээ хязгаарлуулсан эсэх: “Үгүй”
ТШЗ 18.1	Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана” - Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 онд гүйцэтгэсэн жил бүрийн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгөөс багагүй байх;

	<ul style="list-style-type: none"> - Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт: Батлагдсан төсөвт өртгийн 70 хувиас багагүй байх; - Тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өр, төлбөргүй байх.
<p>ТШЗ 18.2</p>	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> - Үнэлгээнд харгалзах санхүүгийн тайлангийн хугацаа: 2022, 2023 он - Харилцагч банкны мэдэгдэл; - Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа; - 2022, 2023 онд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл; - 2022, 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт
<p>ТШЗ 19.1</p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана”</p> <p>Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана”</p> <p>-Барилгын инженер-1 /Тухайн байгууллагын нэр дээр сүүлийн 6-аас доошгүй сар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх/</p> <p>-Цахилгааны инженер-1 /Тухайн байгууллагын нэр дээр сүүлийн 6-аас доошгүй сар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх/</p> <p>-ХАБЭА-н ажилтан-1 /Тухайн байгууллагын нэр дээр сүүлийн 6-аас доошгүй сар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх/</p> <p>-Тендерт санал болгож буй Хүний нөөцийн мэдээллийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15.2-т заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шалгана.</p> <p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардана”</p> <p>-Бага оврын ачааны автомашин – 3.5 тн</p> <p>-Бусад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж</p> <p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана”</p> <p>-Сүүлийн 2 жилийн хугацаанд батлагдсан төсөвт өртгийн 70 хувиас багагүй үнийн дүнтэй 1-ээс доошгүй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх;</p> <p>-Ажил гүйцэтгэх гэрээ, хүлээлгэн өгсөн акт ирүүлэх.</p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардахгүй”</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “Шаардана”</p>

	<ul style="list-style-type: none"> - <i>Компанийн танилцуулга</i> - <i>Тендерт оролцогчийг төлөөлж ажил гүйцэтгэх гэрээ байгуулах эрх бүхий этгээдийн итгэмжлэл</i> - <i>Гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг зөвшөөрсөн эсэх мэдэгдэл</i> - <i>Техникийн тодорхойлолт, ажил гүйцэтгэх технологи аргачлал, нарийвчилсан хугацааны график</i> - <i>Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын тоо хэмжээ, техникийн нөхцлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж, ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</i>
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> - <i>Шаардсан хүний нөөцийг мэдээллийг V бүлгийн маягтын дагуу ирүүлэх;</i> - <i>Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн маягтын дагуу бэлтгэсэн мэдээлэл;</i> - <i>Ажил гүйцэтгэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх гэх мэт);</i> - <i>Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт.</i>
ТШЗ 19.3	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”</p> <p>-БА-2.1 (Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, тохижилтын ажил)</p>
ТШЗ 21.6	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: 2,400,000 төгрөг
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>-Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 22.6-т заасны дагуу тендерийн баримт бичиг, мэдээллийг ил болгохыг зөвшөөрч илгээнэ.</p> <p>-Хуулийн 22.6.1, 22.6.2 дахь хэсэгт заасан баримт бичиг, мэдээллийг нууцалж ирүүлсэн тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу!!!</p> <p>-Хуулийн 22.6.3 дахь хэсэгт заасан мэдээлэл байгаа бол түүний хууль, эрх зүйн үндэслэлийг тодорхой тайлбарлаж ирүүлнэ үү. Хэрэв нууцалсан мэдээллийн хууль, эрх зүйн үндэслэл тодорхой бус, хангалтгүй дутмаг бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу!!!</p>
ТШЗ 26.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:

	Огноо: 2024 оны 08-р сарын 12-ны өдөр Цаг: 13 цаг 00 минут
ТШЗ 26.2	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 08-р сарын 12-ны өдөр Цаг: 13 цаг 35 минут Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Дорноговь аймаг, Улаанбадрах сум, 4-р баг, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын орлогчийн албан өрөө, №008
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ Error! Reference source not found.	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: “Тооцохгүй”
ТШЗ 32.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”
Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ Error! Reference source not found.	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Тийм” Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.
Ё. БУСАД	
ТШЗ 38.1	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Тийм” Урьдчилгаа төлбөр олгох хувь хэмжээ : Гэрээний үнийн дүнгийн 50 хувь хүртэл Гэрээнд заасан маягтын дагуу урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх бөгөөд баталгааг үндэслэж урьдчилгаа төлбөр олгоно.

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн Улаанбадрах сум Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга ажил: /Тус барилга нь 27.4м х 8.0м хэмжээтэй, бетон суурьтай, блокон ханатай, шувуун нуруу дээвэртэй 1 давхар барилга болно/

А. Ажил гүйцэтгэх хугацааны график/ хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Барилга угсралтын ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн саналд зураг төсвийн үнэ 7311400 төгрөгөөр, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тус тус тусгаж ирүүлнэ.

Г. Барилгын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ.

1. Газар шороо, суурийн ажил

- Барилгын газар шороо буйр суурийн ажлыг гүйцэтгэхэд БНБД 3.02.01-90-баримтална. Суурийг механизмаар ухагдаа 20 см –ийн зузаантай үлдээж гараар ухаж өгнө.

- Тус барилгыг цутгамал төмөр бетон шугаман суурьтай байхаар төлөвлөсөн бөгөөд бетоны марк В20, бетон бэлтгэл үеийн 10 см зузаантай бетоны марк В7.5 байна.

- Суурийн ажлыг цутгалтын аргаар гүйцэтгэхэд хэв хашмалыг MNS3173:2002 стандарт, хэвэнд хэрэглэгдэх мод төмөр, хуванцар ба бусад төрлийн дагалдах тоноглол нь MNS0914:86, MNS4237:94, MNS2630:89, MNS2332:89, MNS3219:82-ийн шаардлагыг хангасан байх бөгөөд бетоны бэхжилтийн 70%-г авсаны дараа хэв хашмалыг суллана. Цутгалтанд хэрэглэх хайрга, дайрга MNS0390:1998, бетон зуурмаг нь MNS1185:1985 техникийн шаардлагыг хангасан байна.

Мөн элсийг стандартын шаардлагад тохирсон элс хэрэглэнэ.

Цутгалтын ажил гүйцэтгэхэд БНБД3.03.02-90-г баримтална. Халууны улиралд бетон хийхдээ бетоныг хэт хатахаас хамгаалж өгөх шаардлагатай. Сууринд хэвтээ болон хажуугийн ус тусгаарлагчийг зурагт заасны дагуу хийж өгнө.

- Цутгамал бетон бүтээц БНБД 3.03.01-88-г баримтална. Бетон цутгалтыг дулааны улиралд хийж гүйцэтгэх ба хуурай халуун нөхцөлд бетонд арчилгаа хийх шаардлагатай.

Сууринд хэвтээ болон хажуугийн ус тусгаарлагчийн зурагт заасны дагуу хийж өгнө.

1. Өрөгт бүтээцийн ажил

- Өрөгт бүтээцийн ажлыг зураг төсөвт заасны дагуу гүйцэтгэж БНБД 51-02-05-г баримтална.

-Барилгын гадна ханыг стандарт MNS0831:2001-ийн шаардлагыг хангасан 500кг/м³ эзэлхүүн жинтэй 360мм-н зузаан царууц шохойн гулдмайгаар өрж гадна талаас нь 100мм зузаан хөөсөн полистрол ESP хавтангаар дулаалж тортой шавардлага хийж сайдингаар өнгөлнө.

-Гадна хөөсөн полистрол хавтангийн жин нь 20-23кг/м³ ба стандарт MNS 4629:1998 шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ. Хамар ханыг 75 маркийн ердийн улаан тоосгоор өрнө.

Өрөгт цемент шохойн зуурмаг хэрэглэх бөгөөд тоосгон өргийн зуурмагийн марк 25-г хангасан байна.

2. Хучилт, дээврийн ажил:

- Хучилт, дээврийн ажлыг гүйцэтгэхдээ БНБД 52-02-05, MNS 3073:2001, БНБД-12-01-03, MNS 2797: 2001, БД 52-102-04, БНБД 21-01-02, MNS 4990:2000, БД 52-102-04, MNS3562:83, БНБД 22.01.01, БНБД 81-07-06, БНБД 81-06-06 зэргийг мөрдлөг болгоно.

- Барилга нь шувуун нуруутай модон хучилттай, байна. -Хучилтын дээр дээврийн уур тусгаарлагч, шилэн хөвөн дулаалга дээр дээр нь хар цаас хийж дам нуруутай бэхэлж өгнө.

-Дээврийн дулаалгын ажил нь MNS4929:2005 техникийн шаардлагыг хангасан байна.

- Дээврийн ажлыг хийж гүйцэтгэхдээ ханын уулзвар хэсэгт тоогоор битүүмжилж нүх сүвийг сайтар битүүлж өрнө.

- Дээврийн ажлыг зураг төсөвт тусгасны дагуу гүйцэтгэнэ.

3. Хаалга, цонхны ажил:

- Барилгын хуванцар /PC/ цонх нь Монголд улсад мөрдөж буй норм, MNS-5830:2007 стандарт дулаан техникийн шаардлага хангасан сайн чанарын хуванцар рамтай вакум цонхоор хийх ба барилгын дотор хаалгыг хаалга үйлдвэрлэх тусгай эрх бүхий эх орны үйлдвэрийн стандартын сайн чанарын модон хаалга хийж, гадна хаалгыг дээд зэргийн шаардлагыг бүрэн хангах ба угсралтыг газар дээр нь мэргэжлийн байгууллагаар угсаруулна. Цонх нь заавал салхижуулалтын гэгээвчтэй байна. Цонх цанталтын цэгийг өнгөрөөж суулгана.

- Цонхыг хуванцар рамтай давхар шилтэй салхи шорооноос хамгаалсан, резин хамгаалалт нь стандарт шаардлагыг хангасан эрх бүхий байгууллагаас авч угсарна. Цонхонд хуванцар тавцан суулгах ба мөн гадна талд усны хаялга төмөр угсарч өгнө.

- Бүх гадна дотор хаалгууд 3 хос нугастай, гадна хаалганы цоож, нугас, бариулууд нь гуулин төмрөөр хийгдсэн, ус, дулаан алдахгүй зөөлөвчтэй байна. Хаалганы нугасыг гадна талаас нь задалж болохоор суулгах бөгөөд хаалга цонхны онгойлтуудыг зургийн дагуу хийх ба савалттай хаалганд хязгаарлагч хийж өгнө. Хаалга цонхыг эрх бүхий байгууллагаар хийлгэж угсруулах эсвэл импортын материал худалдан авах тохиолдолд чанартай бат бөхийг сонгон хэрэглэх шаардлагатай.

4.Шалны ажил:

Шалны ажилд БНБД 3.04.04-90, БНБД– 81-11-06 мөрдлөг болгоно. - Шал довжооны дор хийх шороог овойлт, суулт үүсэхгүй хуурай хайрган хөрсөөр 1 үелэн сайтар нягтруулж бетон бэлтгэл цутгаж , цементэн тэгшилгээ хийж шалны керамик хавтанцар ба чулуун плита, паркет зэргийг технологийн дагуу хийх шаардлагатай. Шалыг зургийн дагуу хийж паркетэн шаланд хөвөө угсарна.

- Инженерийн шугам сүлжээ явж байгаа хэсгүүдэд засвар үйлчилгээ хийхэд саадгүй байх нөхцлөөр шалыг хийж өгнө. Мөн шалны бүтээцийн зузаан зураг төсөлд заасантай тохирч байх ёстой. Шалны вааран хавтанцарыг өнгө үзэмжтэй, хальтардаггүй чанартайг сонгон хэрэглэнэ.

4. Гадна, дотор заслын ажил

- Гадна дотор хуурай ба нойтон шавардлага, будаг, цааслалт, шиллэгээ, өнгөлгөөний ажилд БНБД 31-10-05-г мөрдөнө.

- Барилгын гадна хана нь 360 мм хөнгөн блокон ханыг стандартыг хангасан 10см зузаан базальт шилэн хавтангаар дулаалж, металл хавтангаар өггөлж угсарна.

Гүйцэтгэгч нь гадна заслалын материалын өнгө, үзүүлэлтүүдийг зургийн автор архитектор, захиалагч нартай зөвшилцөсний үндсэн дээр гүйцэтгэнэ.. Барилгын гадна заслалын ажлыг хийхээс өмнө ханын нийт гадаргуугийн нүх сүвийг бөглөж цэвэрлэх шаардлагатай.

Гадна цоколын хэсгийг шавардаж хөөрсжүүлэгч хийж сйан чанарын эмульсэн будгаар будна.

- Гадна агаарын температур +8 хэмээс багагүй, өрөөний температур +10 хэмээс багагүй үед заслалын ажлыг гүйцэтгэнэ.

- Дотор ханын шавардлага хийх гадаргууг сайтар цэвэрлэж технологийн дагуу бэлтгэсэний дараа сайн чанарын тэгшилгээ хийж зурагт заасны дагуу өрөө тасалгаа, коридор хэсгийн ханыг шалнаас дээш 2 метр өндөрт тосон будгаар үлдсэн хэсэгт эмульсэн будгаар технологийн дагуу будна. Зочин унтлагын өрөөний хананд тэгшилгээ хийж сайн чанарын обойг технологийн дагуу наана.Таазанд гипсэн хавтан өнгөлгөө хийж сайн чанарын эмульсэн будгаар будна. Цахилгааны шит, тамбурын таазанд дүүжин тааз угсарна.

-Дотор засварын ажилд БНБД3.04.02.88-г мөрдөнө. Заслалын ажилд хэрэглэх материалууд нь MNS5252:2003, MNS4584:98, MNS4581:2003 техникийн шаардлагыг хангасан байна.

- Цонхны амалгааны засварын ажил БНБД3.04.02-88-г мөрдөх ба шавардлагын гадаргуу тэгш, цууралтгүй байх ёстой. Хаалга цонхнуудын амалгаа шавардлагыг хийхийн өмнө гажилтаас хамгаалж нэмэлт хөндлөн бэхэлгээ хийж гүйцэтгэнэ.

5. Гадна шат, довжооны ажил:

- Гадна довжооны цутгалтын ажлыг гүйцэтгэхдээ БНБД 3.03.02-90-г баримтална. Гадна шат, довжооны ажлыг зурагт заасны дагуу барилгын гадна хаалганд газрын өндөржилт, байршилд тохируулан хийнэ.

6. Халаалт, агаар сэлгэлтийн ажил

- Дотор дулааны шугамын холболтыг гүйцэтгэхдээ БНБД 81-18-06, БНБД – 81-19-06, БНБД 3.05.01-88 - г мөрдлөг болгоно.

- Халаалтын шугам нь доогуур түгээлттэй 2 хоолойт мухардмал системтэй байна. Халаалтын системийн магистрал шугамыг 1-р давхрын шалан доор сувагт угсарна. Барилгын температурын заадастай хэсэгт шугам хоолойг дулаалж хийнэ. Хоолойн дулаалгын материалын дулаан дамжуулалтын коэффициент нь $\lambda=0.035$ вт/м²С байх ба түүнтэй адилтгах материалыг хэрэглэнэ. Барилгын халаах хэрэгсэл нь цагаан өнгийн панелин радиатор байна. Халаах хэрэгслийг хананд хөдөлгөөнгүйгээр бэхлэх шаардлагатай. Шугам хоолойд хийх хаалт, хоолой бусад тоноглолыг чанартай материал сонгон хэрэглэх ба хийж гүйцэтгэсний дараа усаар шахаж шалгах шаардлагатай.

- Барилгын халаалтын системийн засвар үйлчилгээг хийхэд тохиромжтой байдлаар гүйцэтгэнэ.

- Салхивчийн агаар сорох системийг Ердийн салхивчийн систем нь төмөр хоолойгоор зураг төсөлд заасны дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.

- Дээвэрт ил гарах агааржуулалтын шахт, яндан хоолой, бохирын хоолой зэргийг цан цохихоос хамгаалж дулаалгын материал ашиглаж дулаалж өгөх шаардлагатай.

Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер БНБД 41-01-11, БНБД 40-01-02, дотор сантехникийн систем БНБД 3.05.01-88 баримталж ажлыг гүйцэтгэвэл зохино.

7. Дотор цэвэр, бохир усны ажил:

- Дотор цэвэр, бохир, усны системийн угсралтын ажлыг гүйцэтгэхдээ БНБД 40-05-98-г мөрдлөг болгоно.

- Цэвэр хүйтэн усны шугамыг цайрдсан ган ГОСТ 3262-75 болон хөнгөн цагаан голчтой хуванцар хоолойгоор, бохир усыг KG-трубы SN-8 хуванцар хоолойгоор дамжуулан бохир усны төвлөрсөн шугамд холбоно. Бохир усны шугамыг сууринд дулаалгын материалаар ороож угсарна. Цэвэр усанд баталгаажсан стандартын шаардлага хангасан тоолуур тавина. Цэвэр усны шугам сүлжээний бөмбөлгөн хаалтууд болон холбох хэрэгсэл тоноглол зэргийг сайн чанарын материалаар хийж гүйцэтгэх ба ил явж байгаа цэвэр, бохир усны шугам хоолойн бэхэлгээг сайн хийх шаардлагатай.

8. Гадна дотор цахилгааны ажил

-Цахилгааны монтажны угсралтын ажлыг гүйцэтгэх үед БД43-101-03, БД 43-102-07, БНБД – 81-20-04, БНБД – 81-30-04 –г мөрдлөг болгоно.

-Дотор цахилгаан тоног төхөөрөмж, кабель утсыг сунгах, утас сүвлэх яндан хоолойг угсрах, шавардлагын доорх далд монтажийн утсыг татж бэхлэх ажлыг угсралтын ажилтай хамт гүйцэтгэнэ. Цахилгааны ажлыг төсөвт тусгагдсан кабелиар барилгын норм дүрэм стандартын дагуу чанартай хийх шаардлагатай.Цахилгааны холболтын ажилд ППВ-3x4 мм², ППВ-1x2.5 мм², ППВ-5x4 мм² ППВ-5x16мм², ППВ-1x10мм² маркийн зэс голтой утас хэрэглэнэ. Унтраалга, разетка нь ус чийгнээс хамгаалагдсан ОХУ-д үйдвэрлэсэн байна.Хятад улсад үйлдвэрлэсэн цахилгааны монтажийн утас хэрэглэхийг хориглоно. Гал тогооны өрөөний цахилгаан тоног төхөөрөмжийг усны хамгаалалттай байхаар сонгон хэрэглэнэ.

-Газардуулгыг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх. Аянгын хэт хүчдэлээс хамгаалах зорилгоор оролтын самбарт ОПС-1 маягийн цэнэг шавхагч тавина.

-Гадна цахилгааны ажлыг зураг төсөл, холбогдох техникийн нөхцлийн дагуу барилгын норм дүрэм стандартын шаардлага хангасан чанартай материал сонгон авч хийж гүйцэтгэнэ.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь: Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлыг гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторын шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ лабораторын шинжилгээний дүн, падаан хавсаргана.

-Барилга угсралтын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

-Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/ -ийн 14.3 заасны дагуу ашиглалтанд өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хий, бүтээц, цэвэр бохир ус,уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

-Гүйцэтгэсэн ажлыг ил далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

-Хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.

-Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлага зэргийг биелүүлнэ.

-Дээрх техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацааг зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

-Үнийн саналыг тооцохдоо Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "Ү" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Улаанбадрах суманд баригдах 6 айлын орон сууцны барилга

А Ж Л Ы Н Т О О Х Э М Ж Э Э

2023/12/01

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
01. Газар шорооны ажил			
1	Барилга барих талбайг 54/80/ морины хүчтэй бульдозероор тэгшлэх	м2	334.40
2	Суурийн шуудуу механизмаар ухаж овоолох	м3	306.66
3	Суурийн шуудууг гараар засч ухах	м3	9.48
4	Төслийн түвшин хүртэл 20см -т гараар ухах	м3	12.30
5	Механизмаар шуудууг шороогоор эргүүлж булах	м3	196.44
6	Шуудууг гараар эргүүлж булах	м3	29.47
7	Суурийн хажуугаар чигжих шороог хийн тромбовкоор нягтруулах	м3	196.44
8	Түрдэг тэргээр шороо зөөж шалан доор 150-200мм хүртэл зузаантай дэвсгэр үе хийж нягтруулах	м3	40.30
02. Суурийн ажил			
9	Бетон бэлтгэл хийх БМ-100	м3	7.96
10	Бетон шугаман суурь цутгах М200	м3	73.19
11	Суурийн дээр төмөр бетон бүс цутгах М-250	м3	31.36
12	Хамар хаын төмөр бетон шугаман суурь цутгах М200	м3	1.78
13	Бүс , хамар ханын арматурын уялдуулга	тн	0.08
14	Сууринд хажуугийн ус тусгаарлагчийг битум түрхлэгээр 2 үе хийх	м2	242.40
03. Хана, хамар ханын ажил			
15	Хэв хашмалтай бүс төмөр бетоноор цутгах М-200	м3	9.33
16	Бүсний арматурын уялдуулга	тн	-0.36
17	375 мм-ийн өргөн гадна ханыг даацтай евро блокоор өрөх/600х250х375/	м3	62.40
18	375 мм-ийн өргөн дотор ханыг даацтай евро блокоор өрөх / 600х250х375/	м3	25.72
19	300 мм-ийн өргөн дотор ханыг евро блокоор өрөх /600х250х300 мм/	м3	21.40
20	100 мм-ийн зузаантай дотор хамар хана евро блокоор өрөх/ 600х250х100 мм/	м3	9.35
21	Тамбурын гадна тоосгон хана арматурлаж өрөх 120 мм	м2	40.12
22	Тамбурын дотор хамар хана тоосгоор өрөх	м2	15.80
23	Тоосгон өрөг бусад хийцийг арматурчлах	тн	0.20
24	0,3тн хүртэл жинтэй ялуу угсрах	ш	34.00
25	0,1тн хүртэл жинтэй ялуу угсрах	ш	15.00
26	2,5м хүртэл урт модон ялуу хийж угсрах	ш	23.00

Улаанбадрах суманд баригдах 6 айлын орон сууцны барилга

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
04. Хаалга цонхны ажил			
27	2м2 дээш талбайтай давхар шилэн багцтай хуванцар рамтай вакуум цонх угсрах	м2	21.60
28	2 м2 хүртэл талбайтай давхар шилэн багцтай хуванцар рамтай вакуум цонх угсрах	м2	12.24
29	Цонхны зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м2	33.84
30	3 м2 хүртэл талбайтай хаалга усрах	м2	13.86
31	Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих	м2	13.86
32	2м2 хүртэл талбайтай бүргэд хаалга суулгах	ш	13.00
33	Хаалганд цоож суулгах	ш	13.00
34	Цонхонд хуванцар тавиур суулгах	м2	11.12
35	Цонхонд усны хаялага төмөр хийх	м2	6.90
05. Шалны ажил			
36	Бетоны дэвсгэр үе хийх М-200 б=150мм	м3	30.22
37	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	168.53
38	Цементэн зуурмаг дээр шалны чулуун плита болон керамик хавтанцар наах	м2	8.54
39	Цементэн зуурмагаар шалны керамик хавтанцар наах	м2	11.60
40	Зөөлөвтэй паркетан шал хийх	м2	168.53
41	Бетон шал цутгах БМ150	м2	12.81
06. Дотор заслалын ажил			
42	Дотор тоосго ба бетон ханыг цемент шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах	м2	521.10
43	Таазанд гипсэн хавтан өнгөлгөө хийх	м2	172.10
44	Таазанд тэгшилгээ хийж сайн чанарын эмульсэн будгаар будах	м2	172.10
45	Хананд замагсан тэгшилгээ хийх	м2	246.22
46	Зочин, унлагны өрөөний хананд сайн чанарын обой наах	м2	246.22
47	Дотор хананд тэгшилгээ хийж 2 метрийн түвшинд өнгийн тосон будагаар будах	м2	195.53
48	Дотор хананд тэгшилгээ хийж сайн чанарын эмульсэн будгаар будах	м2	68.44
49	Цонх хаалганы тэгш гадаргуутай амалгаа шавардах	м2	27.96
50	Цонх хаалганы амалгаанд тэгшилгээ хийж эмульсэн будгаар будах	м2	27.96
51	Узель, шит, тамбурын таазанд төмөр каркастай дүүжин тааз угсрах 600х600	м2	29.43
52	Узель, тамбур, шитний өрөөний дотор хана шавардах	м2	95.27
53	Шавардлагатай хана шохойн будгаар , гар аргаар будах	м2	95.27
07. Гадна заслын ажил			
54	Гадна ханыг металл хавтанцараар шилэн хөвөн дулаалгатай өнгөлөх	м2	171.40
55	Гадна амалгаа металл хавтангаар өнгөлөх	м2	14.72
56	Гадна цоколын ханыг цемент шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах	м2	21.98

Улаанбадрах суманд баригдах 6 айлын орон сууцны барилга

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
57	Шавардсан гадаргууд суурь цавуун хөрсжүүлэгч хийх	м2	21.98
58	Цоколын хана усан эмульсэн будгаар будах	м2	21.98
08. Хучилт дээвэр			
59	Дүнзэн дам нуруу угсрах	м3	6.68
60	Тоосгон ханатай барилгын эрдэс хөвөн дулаалгатай банзан хучилт угсрах	м2	219.20
61	Тамбуурт банзан хучилт хийх	м2	47.82
62	Банзан шувуу нуруу угсрах	м3	7.46
63	Цэвэр банзан карниз угсрах	м2	37.40
64	Харуулдсан банзан фронтон угсрах	м2	14.50
65	Модон сараалжтай долгионт төмөр дээвэр хийх	м2	300.56
09. Бусад ажил			
66	Довжоо хаяачны шороог хийн тромбовкоор нягтруулах	м3	9.24
67	Довжоог, төмөр бетон, гишгүүрийн хамт цутгах БМ150	м3	5.17
68	Арматурын уяалдуулга	тн	0.06
69	Бетон хаяавч цутгах БМ 100	м3	5.88
70	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	58.80
71	Суурийн зүүн урд хэсгийн өндөржилт хийх шороог эксковатороор ухаж автосамосвалд ачиж зөөж авчрах	м3	48.00
72	Шороог механизмаар түрж тэгшлэх	м3	48.00
73	Шороог гараар засч тэгшлэх	м3	9.60
74	Тарааж тэгшилсэн шороог хийн тромбовкоор нягтруулах	м3	48.00
75	Цементэн зуурмаг бэлтгэх	м3	39.30
76	Бетон зуурмаг бэлтгэх	м3	157.50
99. Хог хаягдлын дүн			
77	Хог хаягдал	тн	0.00

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

ДОТОР ХАЛААЛТ, САЛХИВЧ			
Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	D=20мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	120
2	D=25мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	120
3	Халаалтын яндангийн бэлдэц бэлтгэх голч-20мм	м	120
4	Халаалтын яндангийн бэлдэц бэлтгэх голч-25мм	м	120
5	Яндан хоолой хар лакаар будаж дулаалга хийх	м2	16.96
6	Яндан хоолой усаар шахаж шалгах голч d=50мм	м	240
7	Тохируулах хаалт угсрах ф20мм	ком	15
8	Буцаах хаалт угсрах ф20мм	ком	15
9	Хий авагч тавих ф15 мм	ш	15
10	Автомат хий авагч угсрах ф15 мм	ш	2
11	Ус юулэгч хаалт Д-15мм	ш	
12	40мм хүртэл голчтой хог шүүгч тавих	ш	
13	Радиатор угсрах	экм	51.8
АГААР СОРОХ ЕРДИЙН СИСТЕМ			
Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Агаар дамжуулах хоолой угсрах 150x100	м2	12.5
2	Салхивчийн тор суулгах	ш	12

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

ЦЭВЭР УСНЫ ШУГАМЫН АЖИЛ			
Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Дотор ус хангамжийн хөнгөн цагаан голчтой PPR хуванцар хоолой ф 15мм	м	82
